



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.


2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

1110100286



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ” НИЙСЛЭЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Төрөөс баримтлах хүн амын хөгжлийн бодлого 2016-2025”, Ази номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллаганы хөтөлбөр, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хууль эрх зүйн бичиг баримтуудад үндэслэн энэхүү дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

Нийслэлийн хэмжээнд 2017 оны байдлаар **34246** хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байгаагийн **18353** нь эрэгтэй, **15893** эмэгтэй, 0-17 насны хүүхэд 4447 байгаагаас **2420** нь эрэгтэй, **2027** нь эмэгтэй хүүхэд байна. Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь Монгол Улсын Үндсэн хуулинд заасан эрхээ бүрэн эдэлж чадахгүй, тэдний сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах, мэдээллийг жигд хүртэх зэрэг эрх, боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал: нийтийн тээвэр, барилга байгууламж, зам талбай зэрэг үйлчилгээ, дэд бүтцийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай суудал, стандартын шаардлага хангасан тоноглол, тусгай тэмдэглэгээ байхгүй, мэдээлэл харилцаа холбоо нь хүртээмжгүй, тэдний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, нийгмийн зүгээс хандах хандлага нь хангалтгүй байгаа тул тэдний эрхийг хангах, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих нийслэлийн дэд хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага тулгараад байгаа юм.

Уг хөтөлбөрт нийслэлд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамрагдах бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт хүмүүжих боломжийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх, ээлтэй дэд бүтэц, нийтийн тээвэр, мэдээллийн хүртээмжийг сайжруулах замаар тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нэмэгдүүлж эрхийг нь хангана.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 Зорилго

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд тэгш оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт

2.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг /хүн/ ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжих боломжийг бүрдүүлэх;

2.2.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

2.2.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хүргэх;

2.2.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтэц, нийтийн тээврийн үйлчилгээний болон мэдээллийн хүртээмжийг сайжруулах.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

3.1.Нэгдүгээр зорилтын хүрээнд:

3.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэр бүл, хамт олонд түшиглэн сэргээн засах үйлчилгээг үзүүлэх бөгөөд энэ чиглэлээр гарсан тусламж, үйлчилгээний заавар, журмыг хэрэгжүүлнэ.

3.1.2 Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлэх, асаргаа сувилгаа хийх талаар иргэдэд зориулсан зөвлөгөө, мэдээлэл, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.

3.1.3 Ураг, нярай, бага насны хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлэх арга, аргачлалд эрүүл мэндийн ажилтнуудыг сургаж дадлагажуулна.

3.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүлийн гишүүдэд гэрийн асаргаа сувилгаа хийх, сургагч багшийг бэлтгэх сургалт зохион байгуулна.

3.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, уг үйлчилгээг үзүүлэх хүний нөөцийг чадавхижуулна.

3.1.6 Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн дархлааг сайжруулах, витамин дутагдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.7 Цус харвалт болон ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийг нөхөн сэргээх, сэргээн засах үйлчилгээнд хамруулна.

3.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

3.2.1.Цэцэрлэг, сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах ур чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэнэ.

3.2.2.Сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг онлайн, зайны сургалтад хамруулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг /хүн/ боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна.

3.2.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор тэмцээн уралдаан зохион байгуулна.

3.2.4.Багш нарыг чадавхижуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх тусгай хэрэгцээт боловсролын төвийг төрийн болон төрийн бус байгууллагыг түшиглэн байгуулна.

3.3.Гуравдугаар зорилтын хүрээнд:

3.3.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулна.

3.3.3.Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжүүлж ажиллана.

3.3.4.Тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлогт нийцүүлсэн тохируулгатай, байнгын ажлын байр бий болгосон ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3.4.Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

3.4.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулна.

3.4.2.Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтөд дүн шинжилгээ хийж халамжийн үйлчилгээг оновчтой болгоно.

3.4.3.Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд сонсголын болон бусад бэрхшээлтэй иргэдийг дохионы хэлмэрч орчуулагчаар хангаж ажиллана.

3.4.4.Байгалийн гамшиг эрсдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс биеэ хэрхэн хамгаалах, анхны тусламж үзүүлэх талаар сургалт зохион байгуулна.

3.4.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдээллийн нэгдсэн сантай болно.

3.4.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх эерэг ойлголт хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, үе шаттай сургалт зохион байгуулна.

3.5.Тавдугаар зорилтын хүрээнд:

3.5.1.“Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага” MNS 5682:2006, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS6055:2009” стандартуудыг хангуулж ажиллана.

3.5.2.Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр “Цаг үе” хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдээллийн тогтмол цагтай болж мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.5.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж дохионы хэлэнд хөрвүүлсэн daisy болон брайль үсэгтэй номыг хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, нийтэд хүртээмжтэй болгоно.

3.5.4.Хүртээмжтэй нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

3.5.5.Төрийн болон нийтийн үйлчилгээний газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, хөтөчийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1 Хөтөлбөрийн үр дүнг дараах үзүүлэлтээр тодорхойлж, үнэлнэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016 он	Зорилтот түвшин 2022 он
Зорилт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.				
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүл, хамт олонд түшиглэн сэргээн засах чиглэлээр тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	Тоо	60	200

2	Хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо	Тоо	60	200
3	Байнгын асаргаатай хүнийг асрагч нарыг сургах, сургалт зохион байгуулсан тоо	Тоо	23	80
4	Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах	Тоо	10	40
5	Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн дархлааг сайжруулах, витаминь дутагдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Тоо	-	100
6	Цус харвалт болон ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийг нөхөн сэргээх, сэргээн засах үйлчилгээнд хамруулах	Тоо	-	100
Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн /хүүхдийг/ ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжих боломжийг бүрдүүлнэ.				
7	Цэцэрлэг, сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангагдсан хүний нөөцийн тоо	Тоо	5	10
8	Сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг онлайн, зайны сургалтад хамруулсан хүүхдийн тоо	Тоо	20	40
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор тэмцээн уралдаан зохион байгуулсан тоо	Тоо	5	10
10	Багш нарыг чадавхжуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх тусгай хэрэгцээт боловсролын төвийг төрийн ТББ-ыг түшиглэн байгуулах	тоо	-	1
Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.				
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлсэн тоо	Тоо	4	10
12	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	Тоо	1	4
13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан "Ажилд орох зам" сургалтыг зохион байгуулах	Тоо	1	4
Зорилт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэнэ.				
14	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах	Тоо	1	4
15	Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтөд дүн шинжилгээ хийх	Тоо	1	4

16	Байцаан шийтгэх үйл ажиллагаанд сонсголын болон бусад бэрхшээлтэй иргэдийг дохионы хэлмэрч орчуулагчаар хангах	Тоо	25	80
17	Байгалийн гамшиг эрсдлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс биеэ хэрхэн хамгаалах, анхны тусламж үзүүлэх талаар сургалт зохион байгуулах	Тоо	1	1
Зорилт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийн үйлчилгээг сайжруулна.				
18	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй иргэний барилга байгууламжийн тоо	Тоо	-	9
19	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зорчих боломжтой нийтийн тээврийн хэрэгслийн тоо	Тоо	3	6
20	Барилга байгууламж ашиглалтад оруулах комисст ажиллаж байгаа ХБИ-ий тоо	Тоо	3	10
21	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлсэн мэдээллийн цаг	Тоо	4	9

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

5.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. Орон нутгийн төсөв;

5.1.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4. Бусад эх үүсвэр:

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ – ШИНЖИЛГЭЭ

6.1. Нийслэлийн Нийгмийн халамжийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

6.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хоёр жил тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ

6.3. Нийслэлийн Нийгмийн халамжийн газар хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.